



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 8 сарын 28 өдөр

Дугаар 239

Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Голомт капитал ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 199,609,800 /нэг зуун ерэн есөн сая зургаан зуун есөн мянга найман зуу/ төгрөгөөр нэмэгдүүлж хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Голомт капитал ҮЦК” ХХК /О.Мөнхжаргал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны .8. дугаар сарын 26-ны
өдрийн 28-р тогтоолын хавсралт

УХА0410 5043239

“Голомт капитал ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээнд оруулах өөрчлөлт

№	Хувьцаа эзэмшигчийн нэр, /Регистрийн дугаар/	Хувьцааны нэрлэсэн үнэ/₮/	Хувьцааны эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Хувьцааны эцсийн үлдэгдэл			
			Тоо ширхэг	Үнийн дүн/₮/	Эзлэх хувь /%/	Нэрлэсэн үнэ	Тоо ширхэг	Үнийн дүн/₮/	Тоо ширхэг	Үнийн дүн/₮/	Үнийн дүн/₮/	Эзлэх хувь /%/
1	“Голомт фاینэншл групп” ХХК /РД:5845742/	12,000₮	94,200	1,130,400,000	100%	2,119₮	-	199,609,800	14,119₮	94,200	1,330,009,800	100%
	Нийт		94,200	1,130,400,000	100%		-	199,609,800		94,200	1,330,009,800	100%